

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 18-ны өдөр

Дугаар БА-080/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэл, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар, 22 (хорин хоёр) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 210 (хоёр зуун арав) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 11-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/2/3 огноо, 0012304 дугаар,
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: SB-52/2022
- 2.3. Захиалагч: "Арга билиг цамхаг" ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011523079, регистрийн дугаар: 5920213, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, 32, 80 тоот, холбоо барих утас: 99070830, цахим хаяг: info@gb-group.mn ;
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: "Босоо цамхаг констракшн" ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011276123, регистрийн дугаар: 5456096, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ11-599/21, Хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15-р хороо рапид харш 26, 76 тоот, холбоо барих утас: 99999459, цахим хаяг;
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: "Хүчит титэм" ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011597038, регистрийн дугаар: 6050794, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ12-348/20, Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21-р хороо, сэлбийн 27, 676 тоот, холбоо барих утас: 99108920, цахим хаяг;
- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Эс би девелопмент" ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011602135, регистрийн дугаар: 6063373, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: ЗТ12-435/21, Хаяг: Улаанбаатар, Баянзүрх, 26-р хороо, Олимп плаза 1203 тоот, холбоо барих утас: 99109267, цахим хаяг: bayanaa_taiyam@yahoo.com;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

“ГАБОТ” ХХК, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011347012, регистрийн дугаар: 5590396, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: 00458, Хаяг: Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, Хангай хороолол, 507 байр 13 давхар холбоо барих утас: 99115812, цахим хаяг: gabotmgl@gmail.com;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар, 22 (хорин хоёр) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 210 (хоёр зуун арав) айлын орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос

ДҮГНЭСЭН нь:


Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;



- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 32 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар, 22 (хорин хоёр) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 210 (хоёр зуун арав) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, Арга билиг цамхаг ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар, 22 (хорин хоёр) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 210 (хоёр зуун арав) айлын орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Арга билиг цамхаг ХХК-ийн Гүйцэтгэх захирал

(А.Мөнгөн)

(Т.Ганчимэг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САЛД БҮРТГЭЭ.
 Объектын дугаар: 712
 Огноо: 2015 он 01 сар 18 өдөр
 Бүртгэсэн: О. Мунуу
 УЛААНБААТАР ХОТ ТТМ 43764

СҮХБААТАР ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, АРГА БИЛИГ ЦАМХАГ ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 16 ДАВХАР, 22 АВТОМАШИНЫ ДУЛААН
ЗОГСООЛТОЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 210 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ЗОРИУЛАЛТТАЙ
БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, Арга билиг цамхаг ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар, 22 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 210 айлын орон сууцны зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 10 дугаар давхрын 1006 тоотод 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр 14 цагт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|--|-----------------------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч Арга билиг цамхаг ХХК-ийн гүйцэтгэх захирал | Т.Ганчимэг |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын байцаагч | Б.Шинэжаргал |
| 4. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Б.Тэмүүлэн |
| 5. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 6. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК, Ахлах инженер | Э.Ундрахцогт |
| 7. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер | Б.Дашдорж
Н.Болор-Эрдэнэ |
| 8. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК-ийн мэргэжилтэн | Г.Үүрийнгэгээ |
| 9. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер | |
| 10. Онцгой байдлын ерөнхий газар, барилга зураг төсөлд техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа | М.Батсайхан |
| 11. Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын архив, ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 12. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн | О.Ундрах |
| 13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл | Б.Даваасүрэн |
| 14. ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв-6, ахлах инженер | Д.Наранчимэг |
| 15. Зураг төсөл зохиогч байгууллага
Эс би девелопмент ХХК-ийн захирал | Т.Баянмөнх |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 16
- Хүрэлцэн ирсэн - 16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 16

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, Арга билиг цамхаг ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар, 22 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 210 айлын орон сууцны зориулалттай барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Б.Шинэжаргал

- Барилгад ашигласан материалын тохирлын гэрчилгээ, ил далд ажлын акт, тусгай зөвшөөрлүүд, бетоны бат бэхийн шинжилгээний бичгийг үе шат бүрээр, лифтны магадлалын акт улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт БАЗГэрчилгээ үзүүлэх
- Дотор заслын ажил, өрөөний гэрэлтүүлгүүдийг дуусгаж биелэлт ирүүлэх
- Гадна орцны цонхны борооны усны хаялагын төмөр хийх биелэлт ирүүлэх
- Зогсоол руу ордог пандусны дээврийг хийж гүйцээх
- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгааны албан тоот ирүүлэх
- Зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэн баталгаажуулан ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Б.Тэмүүлэн

- Цэвэр усны огтлогооны худагт зураг төсөлд заасны дагуу ус буулгагч хийх
- Цэвэр усны нөөцийн савны гарал үүслийн гэрчилгээ, эрүүл ахуйн дүгнэлтийг шалгуулах
- Бохир усны худгуудад дулаалгатай модон таг хийж өгөх
- Бохир усны худгуудыг орчны тохижилтын өндөржилттэй нийцүүлэх
- Бохир усны салбар шугамуудад цэвэрлэгээний таг хийх
- Цэвэр усны эргэлтийн худгийн холбох хэрэгсэл солих
- Даралт буулгагч хаалтуудыг зураг төсөлд заасны дагуу гүйцээж хийх
- Соронзон хаалт гүйцээж хийх
- Прямок насос гүйцээж хийх
- Нөөцийн савны өрөөнд ус буулгагч болон прямок хийх
- Айлуудын цэвэр усны тоолуурууд дээр коллекторын бэхэлгээ хийх
- Цэвэр усны коллекторыг халаалтын коллектороос тусгаарлалт хийж өгнө

- Чанарын батлагаа гаргах
- Бохир усны гадна шугам өөрчлөлтийн зураг төсөл хийх
- Инженерийн шугам сүлжээний зураг төслийг мэдээллийн санд оруулах
- Нөөцийн савны зураг төсөл шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч

3.Очирпүрэв

- Дулааны гадна шугам худаг бүрт дулаалга бүрэн хийж өнгийн туузаар ялгаж ороох
- Дээвэр дээр үнэр гаргагч дулаалга гүйцээх, таг хийх
- Гадна дулаан, узелийн акт он сар, гарын үсэг гүйцэд баталгаажуулах
- Узелийн өрөөний шал янзлах, (УДДТ) хаягжуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн ахлах инженер

Э.Ундрахцогт

- ДХ-1, 2-р худагт хийсэн шатыг бэхэлж, 2-р худгийн таг бэхлэх
- ДХ-3-р худагт шугам будаж дулаалах
- Нэвтрэх суваг хийгдээгүй болон ДХ-5-р худаг хийгдээгүй дээр тайлбар албан бичиг ирүүлэх
- Узель ХУЦТ-суурилуулж ажилд оруулах
- Айлуудын ариун цэврийн өрөөний дутуу тоноглол гүйцээж суурилуулах
- Гадна дулаан, узель дотор системийн актууд баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, техник хяналтын ахлах инженер

Б.Дашдорж

- Гадна цахилгаан дэд өртөөний гүйцэтгэлийн бичиг баримт, залгах зөвшөөрөл, бусад холбогдох бичиг баримт шалгуулах
- Дэд өртөөг хүчдэлд залгах
- 0.4кв-ын ерөнхий шитний өрөөнд хаяг виржүүлэх, хаалганд схем байрлуулах
- Түр тэжээлийн төлбөр тооцоог шалгаж хүчдэлээс чөлөөлөх.
- Босоо магистралд хаалт хийх, кабель цэгцлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн ахлах инженер

Н.Болор-эрдэнэ

- Зоорийн давхарт кабелийн тавиур суурилуулах (Нийтийн эзэмшлийн талбайгаар суурилуулах)
- Давхрын, самбаруудын сүлжээний утаснуудыг хаягжуулах, цэгцлэх
- Цаашид баригдах барилгуудын давхрын самбаруудыг зургийн дагуу хийж гүйцэтгэх
- Дутуу суурилуулсан камеруудыг гүйцэт суурилуулах
- Шатруу харсан камерийн чиглэл болон байршил өөрчилсөн талаар захиалагч тайлбар ирүүлэх
- Ил далд ажлын акт бүрдүүлэх

- Техникийн давхарт зургийн дагуу галын дохиоллыг мэдрэгч суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер

Г.Үүрийнгэгээ

- А блок барилгын гаргалгаа бохир усны шугамын холбох цэг өөрчлүүлэх зөвшөөрөл хянуулах
- ХМС-нд оруулсан /А блокын/ барилгын баруун тийш гаргасан бохир усны шугамын гүйцэтгэлийн зургийг засуулах
- Гадна бохир усны шугамын ил, далд ажлын актыг /огноотой/ дахин зөв болгож гүйцээж бичих, баталгаажуулан хянуулах
- В блокын доор угсарсан нөөцийн савны зураг шалгуулах
- В блокын доор угсарсан нөөцийн савны зураг шалгуулах
- Угаалга халдваргүйжүүлэлт хийсний дараа НЭМГ-т хүсэлт өгч, унд ахуйн усанд шинжилгээ хийлгүүлэн, дүгнэлийг хянуулах
- Бохир усны худгуудын дулаалгын давхар таг, хөдөлгөөнгүй шат хийж фото зургаар баримтжуулан хянуулах, худгийн кольцо
- Зоорийн давхрын трапны ус шахах суурилуулах
- УСУГ-тай байгуулсан гэрээг шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, барилга зураг төсөлд техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

М.Батсайхан

- Зоорийн давхарт буусан ердийн болон цахилгаан шатны өмнөх гонх хаалт хийх
- Шатны хонгилын тусгаарлах галд тэсвэртэй хаалганд өөрөө хаагч тоноглол хийх
- Тагтанд байрлах аваарын шатыг 5-р давхрын шаланд буулгах
- Шаталтын бүтээгдэхүүн сорох системийн хаях хэсгийг ХАС-24 дугаартай зургийн дагуу болгох
- Гадна хананы дулаалга материалын гал тэсвэршилтийн зэрэг тонтоолгосон дүгнэлт үзүүлэх
- Гал унтраах гадна гидрант хийх
- ГК гал унтраах галын дотор усны даралтат цэг хэвийн болгох
- Зоорийн давхарт гал унтраах автомат спринклерийн систем хийх
- Автомашины дулаан зогсоолыг батлагдсан зураг төслийн дагуу дугаарлаж, хэвтээ, босоо тэмдэг тэмдэглэгээ хийх
- Техникийн давхрын техникийн өрөөнд хаалга хийх
- Нийтийн эзэмшлийн талбайд өөрчлөлт орсон. Зохиогч тайлбар албан бичиг өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний төв архивын газар, Зураг төслийн баримтын ахлах архивч

Э.Шижиртуяа

- Барилгын угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах, ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, баталгаажуулах
- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Норм, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

О.Ундрах

- Техникийн давхрын дээврийн усны хаялганы буултыг хийж, дотуур усны хаялганы хог шүүгчийг тавих
- Шатны хонгилын цонхонд хязгаарлагч хийж, гадна усны хаялга тавцанг хийх
- Бетоны бат бэхийн лабораторийн давхар тус бүрээр нь нөхөж үзүүлэх
- 3 метрээс дээш өндөртэй дотор өрлөгөн ханын хучилтад хийгдсэн төмөр бэхэлгээний акт, фото зураг нөхөж үзүүлэх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм нормативын төлбөрийг тооцуулж төлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл

Б.Даваасүрэн

- Гадна автомашины зогсоолд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авто машинд зориулсан зогсоолыг стандартын дагуу хийх
- В1 давхрын лифтнээс зогсоол руу орох хэсэгт налуу замыг стандартын дагуу хийх
- Лобби хэсгүүдийн гадагшаа гарцанд налуу замыг стандартын дагуу хийх
- Үйлчилгээний төвүүдийн АЦӨ-нд ХБИ, өндөр настанд зориулсан тусгай тоноглолоор тоноглох орон зай төлөвлөх
- Цахилгаан шатанд давхар зарлагч суурьлуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв-6, ахлах инженер **Д.Наранчимэг**

- Гадна ариутгах татуургын худгийг дулаалах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч байгууллага “Эс би девелопмент” ХХК-ийн захирал

Т.Баянмөнх

- Зоорийн давхарт орох явган шат, цахилгаан шатны холбох хэсэгт давхар галд тэсвэртэй хаалга хийх
- Техникийн давхрын парпетны хэсэгт ус зайлуулах цайрдсан төмөр хийх
- Дээврийн борооны ус цуглуулах хоолойн дээд хэсэгт хог шүүх сараалж малгай хийх
- Техникийн өрөөний засалыг гүйцээж хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын ажил гүйцэтгэгч “Босоо цамхаг констракшн” ХХК-ийн захирал

Т.Баясгалан

- Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Комиссын нарийн бичгийн дарга: “Арга билиг цамхаг” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Т.Ганчимэг

- Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- БНБД-ийн 11-04-16 дагуу зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг эцэслэн бичих
- Барилгын ажлыг гүйцэтгэгч БТХ-ийн дагуу чанарын баталгааны албан тоот ирүүлэх
- В1 давхар 12 дулаан зогсоолтой байлгах
- УДДТ-ийн магадлалын нэгдсэн дүгнэлтийг хянуулах
- Нийслэлийн засаг даргын А/1572 захирамжийн дагуу барилгын гадна хашааг буулгах.
- Айлуудын хаалга мөргөлдөж буйд захиалагч, зохиогч, гүйцэтгэгч албан бичиг, тайлбар ирүүлэх
- В1 давхарт батлагдсан зургийн дагуу зогсоолыг хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, Арга билиг цамхаг ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар, 22 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 210 айлын орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Тэмдэглэл хөтөлсөн:
Арга билиг цамхаг ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



(А.Мөнгөн)



(Т.Танчимэг)

анд